



**СЭЛЭНГЭ АЙМАГ
ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 69

Хуурч

**Ойгоос хуш модны самар бэлтгэж, ашиглах
дээд хэмжээг тогтоох тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/372 тоот тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Суманд ойгоос хуш модны самрыг ахуйн зориулалтаар бэлтгэж, ашиглах дээд хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Хуш модны самар бэлтгэн ашиглах ажлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд зохион байгуулж ажиллахыг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн дарга (Н.Амаржаргал), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (М.Гоомарал) нарт тус тус даалгасугай.

3.Тогтоолыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Баянбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЦЭНДСҮРЭН



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 69
дүгээр тогтоолын хавсралт

№	Сумын нэр	Бэлтгэх дээд хэмжээ /кг/
1	Цагааннуур	25000